**Гурванбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчид**

# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДЭЭС ГАРГАСАН ТОГТООЛЫН ЭМХТГЭЛ

**(2012-2015)**

**2015.11.01**

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН ТОГТООЛ

2013 оны 01 сарын 04 өдөр Дугаар _01_ Хөвийн ам

Ñàéí ìàë÷èí øàëãàðóóëàõ ñàíàëûã
äýìæèõ òóõàé

“Аймгийн сайн малчин” шалгаруулах тухай 1 дүгээр áàãèéí Èðãýäèéí Íèéòèéí Õóðëûí òýìäýãëýë, ñóìûí Çàñàã äàðãûí çºâëºëèéí ñàíàë, ìàë÷íû òîãòîðõîéëîëò, àæëûí ¿ç¿¿ëýëò¿¿äèéã õýëýëöýýä Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2009 оны 436 дугаар захирамжыг тус тус үндэслэн ñóìûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎÃÒÎÎÕíü:

Нэг. “Аймгийн сайн малчин” шалгаруулах тухай журам шалгуурыг ханган багийн ÈÍÕ-ын санал, сумын Засаг даргын зөвлөлийн хурлын олонхийн саналаар “Аймгийн сайн малчин”-íä øàëãàðóóëàõààð äýìæèãäñýí 1 дүгээр багийн малчин Балжин îâîãòîé Áаяндалайг “Аймгийн сайн малчин”-íä øàëãàðóóëàõ ñàíàëûã äýìæèí óëàìæèëñóãàé.

Õî¸ð. Б. Баяндалайгийн àæëûí òîäîðõîéëîëò, ¿ç¿¿ëýëò, àíêåò õîëáîãäîõ áàðèìò áè÷ãèéã çààâðûí äàãóó á¿ðä¿¿ëæ àéìãèéí Õºãæëèéí áîäëîãûí õýëòýñò óëàìæëàõûã ñóìûí Çàñàã äàðãûí Òàìãûí ãàçðûí äàðãà Ï.Òîãòîõæàðãàëä даалгañóãàé.

ÄÀÐÃÀ Á.Ï¯ÐÝÂÑÝÍÃÝ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 04 өдөр Дугаар _02_ Хөвийн ам

Итгэмжлэл олгох саналыг
дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Монгол Улсын Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 62.3 дахь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. "Жи Энд Юу Гоулд" ХХК-аас тус сумын нутаг дэвсгэр, байгаль орчинд учруулсан хохирол нэхэмжлэхэд сумын ИТХ-ын даргыг төлөөлж итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр "Хонгор нутгийн дуудлага" төрийн бус байгууллага, энэ хэрэг маргааныг шүүхээр шийдвэрлүүлэх ажиллагаанд Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч Ганболдын Дашдэмбэрэлийг өмгөөлөгчөөр оролцуулахаар гаргасан саналыг дэмжсүгэй.

Хоёр. Уг тогтоолыг тэмдэглэлийн хамт Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч В.Жавхланд уламжилсугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 01 сарын 30 өдөр    Дугаар _05_    Хөвийн ам

Ерөнхийлөгчийн сонгуулийн
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сонгогчийн тоо нь 200-аас бага буюу 193 сонгогчтой байгаа “Пионер толгойн” 5-р багийн хэсгийг “Хөв”-ийн 4-р багийн хэсэгтэй нэгтгэн 284 дүгээр хэсгийг байгуулсугай.

Хоёр. Сонгогчдын санал хурааж, тоолох зорилгоор сонгуулийн хэсгүүдийн дугаар нутаг дэвсгэр, төвийг дор дурьдсанаар байгуулж зарласугай.

Үүнд:

281 дүгээр хэсэг “Цэнгэл”-ийн 1 дүгээр баг төв нь Уст хавчгийн ам

282 дугаар хэсэг “Давааны ам”-ны 2 дугаар баг төв нь Цагаан толгой

283 дугаар хэсэг “Буга”-ын 3 дугаар баг төв нь Багийн төв

284 дүгээр хэсэг “Хөв”-ийн 4-р баг, “Пионер толгойн” 5-р баг төв нь сумын Засаг даргын Тамгын газрын заал

Гурав. Энэхүү тогтоолыг аймгийн ИТХ-д хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга С.Алтанцэцэгт даалгасугай.

ДАРГА    Б. ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 02 сарын 20 өдөр Дугаар _06_ Хөвийн ам

Алдарт эх, эхийн алдар одонгоор
шагнагдах эхчүүдийн материал хүргүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 71 дүгээр зарлигаар батлагдсан журмыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Тус сумаас “Алдарт эх”-ийн нэг, хоёрдугаар одонгоор шагнагдах эхчүүдийн материалыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дээрх эхчүүдийн материалуудыг аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хугацаанд нь хүргүүлэхийг сумын ЗДТГ-ын дарга П. Тогтохжаргалд даалгасугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 02 сарын 20 өдөр Дугаар _07_ Хөвийн ам

┌ ┐
Хуралдаан товлон
зарлах тухай

Ì î í ãî ë Óëñû í Çàñàã çàõèðãààí óòàã äýâñãýðèéí í ýãæ ò¿¿í èé óäèðäëàãûí òóõàé хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын ИТХ-û í Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

Í ýã. Ñóì û í ÈÒÕ-ын ээлжит 4 дүгээр хуралдааныг 2013 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 10 цагт сумын ЗДТГ-ын хурлын танхимд хуралдуулж дараах асуудлуудыг õýëýëö¿¿ëñ¿ãýé. ¯¿í ä:

1. Сумын Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр батлах тухай

2. Ñóì û í ýäèéí çàñàã, í èéãì èéã õº ãæ¿¿ëýõ 2013-2014 оны үндсэн чиглэл батлах òóõàé

3. Сумын Газар зохион байгуулалтын 2013 оны төлөвлөгөө батлах тухай

4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө хуваарилах тухай

5. Жижиг дунд үйлдвэрлэлийн сангийн тайлан. Тухайн санхүүгийн жилд олгох зээлийн хүү, дээд хэмжээ тогтоох, ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай

6. Áóñàä àñóóäàë

Õî ¸ ð. Õóðàëäààí û áýëòãýл хангах ажлын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Гурав. Хуралдааны бэлтгэл хангах ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга С. Àëòàí öýöýã, Çàñàã äàðãûí òàì ãûí ãàçðûí äàðãà Ï .Òî ãòî õæàðãàë í àðò ¿¿ðýã áî ëãî ñóãàé.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 02 сарын 20 өдөр Дугаар _08_ Хөвийн ам

Çº âëº ë ø èí ý÷ëýí áàéãóóëàõ òóõàé

Ì î í ãî ë Óëñûí Ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ òóõàé õóóëèéí 16 äóãààð ç¿éëèéí 1 äýõ çààëòûã¿í äýñëýí ñóì ûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

Í ýã. Ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ àæëûã ñóì ûí õýì æýýíä çî õèöóóëàõ î ðî í òî î í û áóñ çº âëº ëèéã äàðààõ àëáàí òóøààëòíóóäûí á¿ðýëäýõ¿¿í òýé ø èí ý÷ëýí áàéãóóëñóãàé. ¯¿í ä:

Çº âëº ëèéí äàðãà: Ñóì ûí ÈÒÕ-ûí äàðãà

Î ðëî ã÷ äàðãà: Ñóì ûí Çàñàã äàðãà

Í àðèéí áè÷ãèéí äàðãà: Õýñãèéí òº ëº º ëº ã÷

Ãèø ¿¿äýä: Òýðã¿¿ëýã÷äèéí í àðèéí áè÷ãèéí äàðãà

ЗДТГ-ын дарга

Áàéãàëü î ð÷í û óëñûí áàéöààã÷

Öýöýðëýãèéí ýðõëýã÷

Ñî ¸ëûí òº âèéí ýðõëýã÷

Ñóðãóóëèéí í èéãì èéí àæèëòàí

Õ¿í ýì í ýëãèéí í èéãì èéí àæèëòàí

1 ä¿ãýýð áàãèéí Çàñàã äàðãà

2 äóãààð áàãèéí Çàñàã äàðãà

3 äóãààð áàãèéí Çàñàã äàðãà

4 ä¿ãýýð áàãèéí Çàñàã äàðãà

5 äóãààð áàãèéí Çàñàã äàðãà

Õî ¸ ð. 1. Çî õèöóóëàõ çº âëº ëä äààëãàõ í ü:

Ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ òóõàé õóóëèéí 16 äóãààð ç¿éëèéí 3-í 1-7 äàõü çààëòóóäûã óäèðäëàãà áî ëãî í àæëàà óëèðàë, æèëýýð òº ëº âëº í õýðýãæ¿ëòèéã çî õèî í áàéãóóëàí , èðãýäèéí ýðõ ç¿éí áî ëî âñðî ëûã äýýø ë¿¿ëýõ, ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ àæèëä èðãýäèéãº ðãº í î î ðî ëöóóëæ àæèëëàñóãàé.

2. Àæëûí ÿâö òàéëàí ãàà óëèðàë á¿ð сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулан, àéì ãèéí Ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ àæëûã çî õèöóóëàõ çº âëº ëä ÿâóóëæ ÷èãëýë çº âëº ì æ àâ÷ àæèëëàñóãàé.

Ãóðàâ. Ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ àæëûã çî õèöóóëàõ çº âëº ë ø èí ý÷ëýí áàéãóóëàõ òóõàé õî ëáî ãäóóëàí 2010 î í û 03 äугаар ñàðûí 05-í ы º äðèéí 05 äугаар òî ãòî î ëûã õ¿÷èí ã¿é áî ëãî ñóãàé.

ÄÀÐÃÀ Á.Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 19 өдөр Дугаар _09_ Хөвийн ам

Журам батлах тухай

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын Тэргүүлэгчдийн хуралд асуудал бэлтгэн оруулах журам, ажил үүргийн хуваарийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд асуудал бэлтгэн оруулах журмыг 1 дүгээр хавсралтаар, Тэргүүлэгчдийн ажил үүргийн хуваарийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Дээрх журмуудыг мөрдөн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 9 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

## *ГУРВАНБУЛАГ СУМЫН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛД АСУУДАЛ БЭЛТГЭН ОРУУЛАХ ЖУРАМ*

1. Хурлын хуралдааны чөлөөт цагт Тэргүүлэгчид эрх үүргийн хүрээнд шийдвэрлэх асуудлуудыг хэлэлцэн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2. Тэргүүлэгчдийн ээлжит хуралдааныг сар бүр тогтсон өдөр цагт, ээлжит бус хуралдааныг шаардлагатай үед нь Тэргүүлэгчдийн олонхи ирцээр эхлэнэ. Хэлэлцэх асуудлын онцлогтой холбогдуулж хурлыг өргөтгөн Засаг дарга, төрийн болон төрийн бус байгууллагуудын удирдлагууд, иргэдийг оролцуулж болно.

3. Хуралд хурлын Тэргүүлэгчид, Төлөөлөгчид байнгын хороо Засаг дарга Хурлын дарга асуудал санаачилан оруулах эрхтэй.

4. Төр олон нийтийн, аж ахуй нэгж байгууллага, ИНХ-ын дарга, Тэргүүлэгчид, иргэд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.

5. Хуралдаанд оруулах илтгэл, сонсгол, мэдээлэл, хөтөлбөрийг бэлтгүүлэхээр 10-аас доошгүй хоногийн өмнө албан байгууллага асуудал бэлтгэн оруулагч иргэнд мэдэгдэн бэлтгүүлнэ.

6. Хуралдаанд оруулах материалын төслөө хурал эхлэхээс нэгээс доошгүй хоногийн өмнө Тэргүүлэгчдэд хүргүүлнэ.

7. Хуралдаанд оруулхаар бэлтгэсэн илтгэл, сонсгол, мэдээлэл, зэрэг материал нь дараах шаардлага хангасан байна. Үүнд:

- Уг асуудлыг хэлэлцэх болсон шаардлага, өмнө нь энэ асуудлаар эрхийн акт гаргасан эсэх
- Тухайн асуудалтай холбогдсон судалгаа, дүгнэлт хавсрагасан байх
- Гаргах тогтоол, шийдвэрийн төсөл нь: Хууль тогтоолд нийцсэн бүтэц агуулга найруулга сайн, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавьж дүгнэх хариуцах байгууллага эзэн хугацааг заасан хэд хэдэн хувилбартай байж олонхийн саналаар батлагдана.

8. Тэргүүлэгчид гаргасан шийдвэрээ иргэдэд таниулж хэрэгжилтийн явцтай танилцан хянан шалгаж дүгнэн мэдээлж, хуралдаанд болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр ил тод тайлагнана.

9. Тэргүүлэгчид эрх, үүрэг хуулийн хүрээнд нийцүүлэн гаргасан тогтоол нь нутаг дэвсгэрийн хэмжээнд хүчин төгөлдөр байна.

10. Тэргүүлэгчдийн шийдвэр хууль тогтоомжид нийцээгүй нутгийн иргэд байгууллагуудын эрх ашгийг хохироосон байвал Тэргүүлэгчдийн болон ИТХ-ын хуралдааны шийдвэрээр хүчингүй болгоно.

11. Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийг биелүүлээгүйгээс албан байгууллага иргэдэд учирсан хохирлыг буруутай байгууллага албан тушаалтан иргэд хариуцан арилгана.

12. Энэ журамд өөрчлөлт оруулах шинэчлэх шаардлагатай үед Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

13. Энэ журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

______________oOo___________

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 9 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

***ГУРВАНБУЛАГ СУМЫН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ***

**НЭГ: Нийтлэг үндэслэл:**

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид нь Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20-р зүйлийн 1-14 заалт, 20-н 2,3,4-д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Тэргүүлэгчдийн өдөр тутамын үйл ажиллагааг идэвхижүүлэн ил тод нээлттэй ажиллахад Тэргүүлэгчдийн оролцоог сайжруулан хэвийн ажиллагааг хангахад оршино.

**ХОЁР: Тэргүүлэгчдийн хариуцах нийтлэг ажил**

1. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон аймаг сумын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого үндсэн чиглэлийг иргэдэд тайлбарлан таниулах түүний хэрэгжилтийг хангуулах, хянан шалгах дүгнэн мэдүүлэхэд биечлэн оролцоно.

2. Нийгэм эдийн засгийн амьдралын асуудлуудыг иргэн сонгогчид, байгууллагууд нарийн судалж дүгнэлт гарган Тэргүүлэгчдийн болон хурлын хуралдаанд асуудал санаачилан боловсруулж оруулах.

3. Тэргүүлэгчдийн ажилын төлөвлөгөө, энэ аувааарийг сар , улирал, жилд хэрэгжүүлэхээр зааж хариуцсан ажлуудыг хэрэгжүүлж тайлагнах.

4. Иргэд тойргийнхоо сонгогчидтойгоо уулзалт хийн аж амьдралтай нь танилцах санал хүсэлтийг сонсох, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах , сонгогчдод амласан амлалт мөрийн хөтөлбөрөө тайлагнах /хурал сонгогчдод/

5. Хурлын ээлжит болон , ээлжит бус хуралдааны бэлтгэл хангах , угтаж зохиосон ажилд оролцон зохион байгуулах, хэлэлцүүлж байгаа асуудалд оновчтой санал санаачлага гарган шийдвэрт тусгах.

6. Багийн иргэдийн нийтийн хурал, Тэргүүлэгчдийн ажилтай танилцах хуралдаанд нь оролцон тэдэнд эрх зүй. Ажил хэргийн зөвлөмж , чиглэл өгөх.

7. БИНХ-ын ажлын тайлантай танилцаж урамшуулал олгох

8. Хурлын хяналт шалгалтын асуудал, хурал тэргүүлэгчдийн тогтоол багт хэрхэн хэрэгжиж байгаа байдал.

9. Үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих.

10. Хууль тогтоолын хэрэгжилт сумын хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих.

11. Төрийн болон орон нутгийн өмчийн эзэмшилт ашиглалт хамгаалалтын асуудал.

12. Орон нутагт Улсын төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрт хяналт тавих

13. Нийтийн үйлчилгээ, ундны усны хангамж, ариун цэвэр, ахуйн хог хаягдлыг бууруулах ажлын хэрэгжилтэнд хяналт тавих

14. БИНХ-д иргэдийн оролцоог идэвхижүүлэх. /Сонгогдсон тойрог багтаа /

**ГУРАВ: Тэргүүлэгчид нийтлэг хариуцах ажлын зэрэгцээ нэг бүрчлэн дараах ажлыг хариуцна.**

***Хурлын дарга:***

1. Сумын ИТХ-ын хуралдаан, Тэргүүлэгчдийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.

2. Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22-р зүйлд заасан нийтлэг бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх ажил.

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлийн ажил.

4. Монголын улаан загалмайн ажил.

5. Хуулинд заасан бусад ажил

6. Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан болон тойрогтоо ажиллах асуудал.

7. Төлөөлөгчид Тэргүүлэгчдийн хурлын шийдвэр хууль тогтоолын хэрэгжилтэнд тавих хяналт.

***Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга:***

1. Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20-р зүйлийн 4 дэх заалтын дагуу тэргүүлэгчдийн ажилын албаны дарга байна.

2. Тэргүүлэгчдийн жил, улирлын ажлыг иргэд Тэргүүлэгчдийн саналыг тусган төлөвлөж Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн батлуулж сурталчилан хэрэгжилтийг зохион байгуулж дүгнэн мэдээлэх

3. Тэргүүлэгчид Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20-р зүйлийн 1-14 заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслах, эрх зүй, ажил хэргийн зөвлөмж өгөх, гарын авлага материал хүргэх.

4. Тэргүүлэгчдийн хуралд асуудал бэлтгэн оруулах журам, Тэргүүлэгчдийн хариуцах ажил үүргийн хуваарийг боловсруулан батлуулж мөрдөн улирал тутам дүгнэх.

5. Хурлын хуралдаан, Тэргүүлэгчдийн хурлын шийдвэр, бодлого хөтөлбөр, чиглэлийг сурталчлан таниулах, хэрэгжилтийг зохион байгуулах, дүгнэн мэдээлэх.

6. Хурал Тэргүүлэгчдийн дотоод ажил, тайлан мэдээ мэдээллийг хариуцах.

7. Иргэдийн санал, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлүүлж хариуг өгөх.

8. Улс төрийн хэрэгт хилсээр хилмэгдээд \1930-1940\ өөд цагаадаагүй иргэдийн талаар судлах сурвалжлах, тодруулах ажил.

9. Хурлын Төлөөлөгчдийн хуралдаан болон тойрогтоо ажиллах ажил хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих.

10. Хурал Тэргүүлэгчдийн мэдээлэл, сурталчилгааны ажил, хурлын ил тод нээлттэй хэвийн ажиллагааг хангах, иргэдийн оролцоо идэвхийг өргөтгөх.

11. Хурлын байнгын хороо, түр хороо, ажлын хэсгийн ажлыг чиглүүлэх хэрэгжилтийг дүгнэн тайлагнах , мэдээлэх.

12. БИНХ-ын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөмж чиглэл өгөх, улирал тутам ажлыг нь дүгнэн мэдээлэх.

***Тэргүүлэгчид:*** Тус бүрдээ хариуцах ажил

1. Ахуйн болон соёлын байгууллага, иргэдийн амьдрах орчин ариун цэвэр тохижилтын ажил, хурал Тэргүүлэгчдээс нийтээр дагаж мөрдүүлэхээр баталсан журмын хэрэгжилт, Сумын төвийн айл өрх , албан байгууллагуудын тохижилтын ажил. Тэргүүлэгч Д.Баяржаргал

2. Улаан загалмайн гишүүд идэвхитэний эгнээг өргөтгөх. Тэргүүлэгч Г.Ууганбаяр

3. Өсвөрийн улаан загалмайн эгнээг өргөтгөх. Тэргүүлэгч Н.Оюунмаа /Ц.Энхболд/

4. Хүн ам биеийн тамир спортын ажил, энэ талаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилт. Тэргүүлэгч Б.Баяндалай

5. Иргэдийн амжиргаар дээшлүүлэхтэй холбогдсон төсөл хөтөлбөрийн хэрэгжилт. Тэргүүлэгч Ц.Баатаржав.

6. Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, тэдний санал санаачлагыг хурлын шийдвэрт тусган хэрэгжилтийг мэдээлэх. Тэргүүлэгч Д.Баяржаргал

7. Сумын хурал, төсөвт байгууллагын төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтын асуудал . Тэргүүлэгч Э. Жавхлан

8. Санхүү бүртгэл, төсвийн төлөвлөлт , мэдээ мэдээллийн ажил. Тэргүүлэгч Э.Жавхлан

9. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, байгаль орчноо хамгаалах ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн тухай. Тэргүүлэгч Б.Баяндалай

10. Сумын нутаг дэвсгэр дээр ашигт малтмалын олборлолт явуулж байгаа компанийн үйл ажиллагааны талаар. Тэргүүлэгч Б.Баяндалай

11. Сумын бэлчээр, хадлангийн талбайн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, хэрэгжүүлэх журмын хэрэгжилт. Тэргүүлэгч Г.Ууганбаяр

12. Иргэн хүн амын соёл, боловсролын асуудлаар чиглэл хөтөлбөрт тусгагсан ажлын хэрэгжилт Тэргүүлэгч Н.Оюумаа /Ц.Энхболд/

***Хурлын ажилтан:***

1. Сум аймгийн ИТХ-н тогтоол шийдвэр сурталчлах, сургалт мэдээллийн ажил

2. Төлөөлөгчид Тэргүүлэгчдийн эрх зүйн боловсрол, сургалт танин мэдэхүйн асуудал.

3. Албан хэрэг хөтлөлт ,бичиг хэргийн эргэлт, архивийн ажил.

_______оОо_______

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 19 өдөр Дугаар _10_ Хөвийн ам

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "ж" дэхь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 30 дугаар тогтоол тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Багийн ИНХ-ын дарга, Тэргүүлэгчдийн ажил дүгнэх журмыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дээрх журмыг мөрдөн ажиллахыг багийн ИНХ-ын дарга, Тэргүүлэгчдэд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 10 дугаар
тогтоолын хавсралт

## *БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭГЧДИЙН АЖЛЫГ ДҮГНЭХ ЖУРАМ*

***ЗОРИЛГО:*** Баг нь нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг нийгмийн аливаа асуудлыг хуулиар олгогдсон эрхийн хүрээнд шийдвэрлэдэг байх чадамжийг бүрдүүлэх аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар баталсан багийн ИНХ-ын ажлыг дүгнэх журам, Багийн ИНХ-ын Дарга нарт урамшуулал олгох журмын зарим зүйлийг тодотгоход журмын зорилго оршино.

### *ЕРӨНХИЙ ЗҮЙЛ*

1. Багийн ИНХ-ын Тэргүүлэгчид жилийн ажлын төлөвлөгөөтэй ажиллах ба төлөвлөгөөгөө 1 дүрээр сард багтаан баталсан байна.
2. Багийн ИНХ-ын тэргүүлэгчидийг сард 1-ээс доошгүй удаа Иргэдийн нийтийн хурлыг жилд 3-аас доошгүй удаа хуралдуулж багийн нийгэм эдийн засгийн гол зангилаа асуудлуудыг хэлэлцэнэ.
3. Багийн ИНХ-ын дарга, Тэргүүлэгчдийн тухайн сард хийсэн ажлынхаа тайланг сар бүрийн 20-25-ны хооронд Хурлын ажлын албанд ирүүлж байна.
4. Сумын ИНХ-ын Тэргүүлэгчид ажлын тайланг журмын дагуу хэлэлцэн зохих урамшууллыг багийн ИНХ-ын даргад олгоно.
5. Сарын ажлын тайлангаа хугацаанд нь ирүүлээгүй БИНХ-ын даргад тухайн сарын урамшууллыг олгохгүй.
6. БИНХ-ын Тэргүүлэгчдээр сонгогдож ажиллаж байгаа иргэн нь ИНХ-ын ажилд оролцохгүй буюу идэвхи санаачлага муутай ажиллаж байгаа бол Тэргүүлэгчдийг ИНХ-ын даргын саналаар, ИНХ-ын даргыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн саналаар өөрчлөх асуудлыг ИНХ-д тавьж шийдвэрлүүлнэ.
7. Жилд 3 удаа сарын ажлынхаа тайланг ирүүлээгүй БИНХ-ын даргыг энэ журмын 6-д заасанаар шийдвэрлүүлнэ.

### *ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ*

1. БИНХ-ын дотоод ажил бичиг хэргийн бүрдлийг стандартын дагуу хөтлөх
2. БИНХ-ыг жилд 3-аас доошгүй удаа хуралдуулж багийн нийгэм эдийн засгийн гол зангилаа асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.
3. Тэргүүлэгчдийн хурлыг сард 1-ээс доошгүй удаа хуралдуулж хэвших.
4. БИНХ-ын шийдвэр гаргаж багтаа жилд 1-ээс доошгүй бүтээлч ажил зохион байгуулсан байх.
5. Өөрийн багийн ажил үйлсийг сурталчилсан 7 хоногийн аян зохион байгуулж, энэ үеэр Нэг баг, нэг шилдэг бүтээгдэхүүн үзэсгэлэн худалдаа зохион байгуулах
6. Багийн иргэдийн дунд хууль сурталчлах ажлыг олон хэлбэрээр зохион байгуулах
7. Нийгмийн дэг журам, архидалт, хулгайтай тэмцэх талаар тодорхой шийдвэрүүдийг гаргаж хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан байна.
8. БИНХ-ын материалыг хуралдаан тус бүрээр нь эмхтгэж хуралдаан болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, Тэргүүлэгчдийн хурлын материалыг жилээр эмхтгэж дараа жилийн 1 дүгээр сарын 10-ны дотор Хурлын ажлын албанд ирүүлсэн байна.
9. Багийн хөгжлийн сантай болж түүнийг бүрдүүлэх, зарцуулах журмыг батлан мөрдөх
10. Багийн ард иргэдийн бүх төрлийн судалгаатай болох

11. Улаан загалмайн гишүүд идэвхитнүүдийг эгнээг өргөтгөх, хандив, татвар хураах

***ДҮГНЭХ***

1. БИНХ-ын ажлыг 6, 12 дугаар саруудад сумын ИТХ-ын Тэргүүлэгчид шалгаж дүгнэнэ.

2. Жилээр байр эзлүүлнэ.

3. Үзүүлэлт бүрт хийгдсэн ажил байдлыг нь харгалзан 0-5 оноо өгч дундаж оноог гаргахдаа үзүүлэлт тус бүрт өгсөн онооны нийлбэрийг дүгнэсэн үзүүлэлтэд хуваан гаргана.

Авсан оноо нь:
4.6-5.0 ажил тогтмолжсон \сайн\
3.6-4.5 ажил сайжирсан \хэвийн\
3.0-3.5 ажил сайжрах үндэс тавигдсан \дунд\
2.9-өөс доош оноо авсан бол хангалтгүй гэж үнэлнэ.

4. Хэвийн буюу түүнээс дээш үнэлгээ авсан багуудаас байр эзлүүлнэ. 1, 2-р байр эзэлсэн БИНХ-ын дарга, Тэргүүлэгчдийг мөнгөн болон тусгай шагналаар шагнаж урамшуулна.

5. Хангалтгүй үнэлгээ авсан БИНХ-ын дарга, Тэргүүлэгчдийг өөрчлөх асуудлыг ИНХ-д санал болгож шийдвэрлүүлэх .

_______________оОо______________

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 19 өдөр Дугаар _11_ Хөвийн ам

Журам батлах тухай

Сумын 5-р багийн Засаг даргын “Нохой тэжээхэд мөрдөх журам”-ын төслийг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумд “Нохой тэжээхэд мөрдөх журам”-ыг хавсралтаар батлсугай.

Хоёр. Дээрх журмыг мөрдөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж сар тутам сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 11 дүгээр тогтоолын хавсралт

## *НОХОЙ ТЭЖЭЭХЭД МӨРДӨХ ЖУРАМ*

Нэг. Зорилго

1.1 Сумын нутаг дэвсгэр, сумын төвийн гудамж хороололд эзэнгүй нохой хэт олширч хүн мал сүрэгт халдварт өвчин тараах нөхцөл бий болж хүний эрүүл мэндэд аюул учруулах орчны бохирдлыг ихэсгэж буй сөрөг үзэгдлүүдийг арилгах.

1.2 Өмч хөрөнгө аюулгүй байдлаа хамгаалуулхаар тэжээж буй нохойг гэрчилгээтэй болгон уях, тавих цагийг мөрдүүлэн мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх, тарилга туулгалтад бүрэн хамруулан эрүүл цэвэр орчин бүрдүүлэхэд журмын зорилго оршино.

Хоёр. Засаг даргын Тамгын газрын хүлээх үүрэг

2.1 Энэхүү журмын хэрэгжилтэд байнга хяналт тавьж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ

2.2 Журмын хэрэгжилттэй холбогдсон албан хаагчид, мэргэжилтнүүдтэй болон иргэдийн саналыг хүлээн авч шийдвэрлэж байх.

2.3 Журмын хэрэгжилтийг багийн Засаг дарга нар болон холбогдох хүмүүсийн ажил дүгнэх үзүүлэлтэнд тооцох.

Гурав. Багийн Засаг дарга нарын хүлээх үүрэг

3.1 Нохой тэжээж буй айл өрхийн бүртгэл гарган сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс тогтоосон татварыг өрх бүрээр тооцон хурааж орон нутгийн орлогын дансанд тушаана.

Татвар /жилдээ/: Эр нохой - 3000 төгрөг
Эм нохой- 7000 төгрөг

3.2 Хөдөөний айл, хот ,хаваржаа, өвөлжөөний орчин гудамж талбайн цэвэрлэгээг холбогдох байлууллага хүмүүстэй хамтран цэвэрлүүлж хяналт тавих.

3.3 Нохой тэжээдэг айл өрх бүрийг “Тэжээвэр нохой бүртгэх” дэвтэртэй болгон тарилга туулгалт хийсэн, татвар хураамж авсан тухай бүр тэмдэглэл хийнэ.

3.4 Багийн Засаг дарга нар Мал эмнэлгийн байгууллагатай хамтран гаргасан нохойны бүртгэлийн дагуу номер, гэрчилгээ олгон, нэгдсэн нэг өнгийн хүзүүвчтэй болгон, файзжуулж, тарилга, туулгалт хийж шаардлагатай бол эр нохойг хөнгөлөх ажлыг зохион байгуулна.

3.5 Нохой болон гэрийн тэжээвэр амьтан тэжээх аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар иргэдэд ухуулга, сурталчилгаа хийж орчны бохирдол, эрүүл ахуйн байдалд хяналт тавьж ариун цэврийн хяналтыг өндөржүүлж ажиллах.

3.6 Шаардлагатай тохиолдолд эзэнгүй золбин нохойг устгах ажлыг сумын ЗДТГ, Мал эмнэлэгтэй хамтран зохийн байгуулж шийдвэрлэсэн байх

Дөрөв. Нохой тэжээгч айл, иргэдийн хүлээх үүрэг

Сумын иргэд Монгол угшлын \банхар\ хэв шинжийг хадгалсан үс, санхарцаг, зүс өнгө байдлыг харгалзан нохойг тэжээх зорилго тавих.

4.1 Иргэдийн амгалан тайван байдал, эрүүл мэндэд аюул учруулахгүйн тулд нохойг өглөөний 07 цагаас 23 цаг хүртэл уяатай байлгах, хашааныхаа хаалган дээр таних тэмдэг тависан байх.

4.2 Өрх бүр нохойг багийн бүртгэрд хамруулан тарилга, туулгалт, хийлгэн татварыг өгч тэжээвэр нохойг бүртгэх дэвтэрт тэмдэглэгээ хийлгэсэн байх.

4.3 Өрх бүр тэжээж буй нохойгоо өөрийн харъяа багийн Засаг даргад бүртгүүлж, нэгдсэн нэг өнгийн хүзүүвчтэй болгон, файзжуулна. Үүнийг нэгдсэн журмаар зохион байгуулах тул гэрчилгээ, хүзүүвч, файзыг заавал худалдан авна.

4.4 Нохойны ялгадасыг тусгай савлан хөдөөд тусгай цэгт \нүхэнд\ төвд хогийн цэгт асгах бөгөөд хашааныхаа хойд, урд талыг тогтмол цэвэрлэж бай.

4.5 Энэ журмын дагуу холбогдох хүмүүсээс өгсөн үүрэг даалгаварыг хугацаанд нь биелүүлж ажиллах.

4.7 Тогтоосон цагт нохойгоо уялгүйгээр хүн зуулгасан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу учирсан хохирлыг нөхөн барагдуулна.

__________оОо_________

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 19 өдөр Дугаар _13_ Хөвийн ам

Зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Сумын нийгмийн халамжийн ажилтан Б.Циегийн саналыг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт, 27.6 дахь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын амьжиргааг дэмжих зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Дарга: Сумын ЗДТГ-ын дарга /П.Тогтохжаргал/

Нарийн бичгийн дарга: Сумын нийгмийн халамжийн ажилтан /Б.Циеэ/

Гишүүд: Сургуулийн нийгмийн ажилтан /Г.Эрдэнэсувд/

Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан /Д.Баяраа/

Ц.Баатаржав /Сумын ИТХ-ын Тэргүүлэгч/

Д.Дагважамц / 5-р багийн Засаг дарга/

Хоёр. Нийгмийн халамжийн тухай хууль, түүнтэй холбогдолтой гаргасан хууль тогтоомж бусад эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажиллаж ажлын явц, үр дүнг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд улирал бүр тайлагнаж ажиллахыг зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 06 сарын 10 өдөр Дугаар _19_ Хөвийн ам

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн, Засгийн газрын “Ажилтай орлоготой Монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сумын хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, ажилгүдэл, ядуурлыг бууруулах, шинэ ажлын байр бий болгох, нийгмийн түншлэлийн 3 талт байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын нийгмийн гурван талт түншлэлийн байгууллагуудтай хамтран “Хөдөлмөрийн бага чуулган” зохион байгуулж, 2013-2016 онуудад хэрэгжүүлэх “Хөдөлмөрийн аян”-ыг удирдлага зохион байгуулалтаар хангах “Зохион байгуулах хороо”-ны бүрэлдэхүүнийг дор дурьдсанаар баталсугай.

Ахлагч: Д. Банзрагч - Сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Ч. Саранзая – Нийгмийн хөгжлийн ажилтан

Гишүүд: П. Тогтохжаргал – ЗДТГ-ын дарга

Ц. Энхболд – Халун тал ТББ-ын тэргүүн

Ж. Чулуунбат – “Өсөн дэвжих арвижих” хоршооны эзэн

Д. Дагважамц – 5-р багийн Засаг дарга

Р.Үүрдмандах – Улсын сайн малчин /1-р баг/

Х.Мядагбадам – МЭҮТ-ийн мэргэжилтэн

Э.Жавхлан – ИТХ-ын Тэргүүлэгч

Хоёр. “Хөдөлмөрийн аян”-ыг 2013-2016 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж 2013.01.17-ны өдрийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхийг “Зохион байгуулах хороо” /Ч.Саранзаяа/-д даалгасугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 10 өдөр Дугаар _20_ Хөвийн ам

Хурлын шийдвэр хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, сумын ИТХ-ын 2010.07.07-ны өдрийн 8/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын усан сангийн барилгуудыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газар бариагүй, мөн иргэд зөвшөөрөлгүй /төлөвлөгөөнд тусгагдаагүй/ газар хашаа хатгаж буусан, хашааны газраа өргөтгөсөн зэрэг зөрчил дутагдлуудыг арилгах, төлөвлөгөөнд тусгагдсан газар нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг 2013.06.17-ны өдрийн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Банзрагч/, Засаг даргын Тамгын газрын дарга /П.Тогтохжаргал/, байгаль орчны хяналтын улсын байцаагч /Ш.Нархүү/, газрын даамал /Д.Оргилбаяр/ нарт үүрэг болгосугай.

Хоёр. Газрын тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Банзрагч/-д үүрэг болгосугай.

ДАРГА Б. ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 06 сарын 10 өдөр Дугаар _21_ Хөвийн ам

Хуралдаан зарлан хуралдуулах тухай

Ì î í ãî ë Óëñûí Çàñàã çàõèðãààí óòàã äýâñãýðèéí í ýãæ ò¿¿í èé óäèðäëàãûí òóõàé хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын ИТХ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õí ü:

Í ýã. Ñóì ûí ÈÒÕ-ûí ýýëæèò 5 дугаар хуралдааныг 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 9 цагт сумын ЗДТГ-ын хурлын танхимд хуралдуулж дараах асуудлуудыг õýëýëö¿¿ëñ¿ãýé. ¯¿í ä:

1. Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2013 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт явцын тухай

2. Сумын Газар зохион байгуулалтын 2013 оны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилт явцын тухай

3. Сумын дунд хугацааны зорилго, зорилт батлах тухай

4. Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилт явцын тухай

5. Жижиг дунд үйлдвэрлэлийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийн хяналт шалгалтын дүнгийн тухай

6. Áóñàä àñóóäàë

Хоёр. Хуралдааны бэлтгэл хангах ажлын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Гурав. Хуралдааны бэлтгэл хангах ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг ИТХ-ын ажлын алба /С.Алтанцэцэг/, Засаг даргын тамгын газар /Ï .Òî ãòî õæàðãàë/-т үүрэг болгосугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 28 өдөр Дугаар _24_ Хөвийн ам

Хуралдааны тов өөрчлөх тухай

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын ИТХ-ын ээлжит 5-р хуралдаан 2013.07.01-ний өдөр Сумын төвд хуралдах байсан боловч Аймгийн ИТХ-ын ээлжит хуралдаан 07-р сарын 01-ний өдөр зарлагдаж сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нар хуралдаанд оролцох, мөн 07-р сарын 01-ээс багийн 07-р сарын 05-ны хооронд багуудын өдөрлөгүүд эхлэж төлөөлөгчдийн ирц бүрдэхгүй байж болох шалтгааны улмаас хурлын хуралдааныг 2013 оны 06 сарын 30-ны өдөр болгон өөрчилсүгэй.

Хоёр. Сумын ИТХ-ын хуралдааны тов өөрчилсөн зарыг төлөөлөгчдөд хүргэх ажлыг зохион байгуулахыг ИТХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 26 өдөр Дугаар _23_ Хөвийн ам

┌ ┐
Ээлжит бус хуралдаан зарлан
хуралдуулах тухай

Ì î í ãî ë Óëñûí Çàñàã çàõèðãààíû íóòàã äýâñãýð, òүүíèé óäèðäëàãûí òóõàé хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн сумыí ÈÒÕ-ûí Òýðãүүëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

Í ýã. Ñóì ûí ÈÒÕ-ын ээлжит бус 6 дугаар хуралдааныг 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 10 цагт сумын Соёлын төвд хуралдуулж дараах асуудлуудыг õýëýëöүүëñүãýé. ¯үí ä:

1. Алтны уурхайн үйл ажиллагааны тухай

2. Зохион байгуулалтын асуудал

3. Бусад асуудал

Хоёр. Хуралдааны бэлтгэл хангах ажлын хөтөлбөрийг хавсралтаар батлсугай.

Гурав. Хуралдаанд иргэд хөдөлмөрчдийг оролцуулах, зар хүргэх ажлыг зохион байгуулж ажиллахыг багийн ИНХ-ын дарга, Тэргүүлэгчид, Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 26 өдөр Дугаар _25_ Хөвийн ам

Ажил эрчимжүүлэх тухай

Ì î í ãî ë Óëñû í Çàñàã çàõèðãààí óòàã äýâñãýðèéí í ýãæ ò¿¿í èé óàèðäëàãû í òóõàé õóóëèéí 25 äóãààð ç¿éëèéí 25.1 äэх çààëò, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтыг тус тус ¿í äýñëýí ñóì û í Èргэдийн Òөлөөлөгчдийн Õурлûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õí ü:

Í ýã. Тус сумын Хөвийн амны 4 дүгээр багийн нутаг Өвөр хөшөөтөд MV-0012806 лиценз эзэмшигч “Жи Энд Юу Гоулд” ХХК нь нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн ерөнхий шүүгч Ц. Батсүрэнгийн 2013 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 623 дугаар захирамжийг зөрчсөн, аймгийн Засаг дарга, Байгаль орчин аялал жуулчлалын газраас үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл аваагүй, сумын Засаг даргатай ус, газар ашиглалтын гэрээ байгуулаагүй үйл ажиллагаа явуулж байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтыг зөрчиж байгаа тул “Жи Энд Юу Гоулд” ХХК-ны үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга Д. Банзрагчид зөвлөсүгэй.

Хоёр. Дээрх үйл ажиллагаатай холбоотой зохион байгуулсан ажил, мэдээллийг өдөр бүр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд /энэ асуудлаар эцэслэн шийдвэр гартал/ мэдээлэлж ажиллахыг сумын Засаг дарга Д. Банзрагчид үүрэг болгосугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 10 сарын 07 өдөр Дугаар _27_ Хөвийн ам

Удирдах зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Ì î í ãî ë Óëñûí Çàñàã çàõèðãààíû íóòàã äýâñãýðèéí íýãæ òýãýýí èéí óäèðäëàãûí òóõàé хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн сумын ИТХ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õí ü:

Нэг. Сумын Улаан загалмайн хорооны удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Удирдах зөвлөлийн дарга: Б.Пүрэвсэнгэ – ИТХ-ын дарга

Нарийн бичгийн дарга: Н.Оюумаа – ИТХ-ын Тэргүүлэгч

Гишүүд: О.Бадамдорж – 1-р багийн ИНХ-ын дарга

Ч.Мөнхбаатар – 2-р багийн ИНХ-ын дарга

О.Болд – 3-р багийн ИНХ-ын дарга

Ц.Батмөнх – 4-р багийн ИНХ-ын дарга

Д.Батбаатар – 5-р багийн ИНХ-ын дарга

Хоёр. Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн үүрэг, зорилгыг ард иргэдэд сурталчилах, гишүүд дэмжигчдээс гаргасан санал хүсэлтийг уламжлах, хүмүүнлэгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, татвар, хандив төвлөрүүлэх ажилд идэвхи санаачлага гарган ажиллахыг удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

Гурав. Ажлын явц тайлангаа хагас, бүтэн жилээр дүгнэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж зөвлөмж чиглэл авч ажиллахыг зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 20 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 07 өдөр Дугаар _28_ Хөвийн ам

Комисс шинэчлэн байгуулах тухай

Ì î í ãî ë Óëñû í Çàñàã çàõèðãààíû í óòàã äýâñãýðèéí í ýãæ ò¿¿í èé óäèðäëàãûí òóõàé хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “л” дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалтыг тус тус үндэслэн ñóì ûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õí ü:

Нэг. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах эрх бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Төрийн сангийн төлөөлөгч /Б.Цэдэндамбаа/

Нарийн бичгийн дарга: ЗДТГ-ын дарга /П.Тогтохжаргал/

Гишүүд: Сургалтын менежер /Н.Туяацэцэг/

Эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч /Т.Наранцацрал/

Цэцэрлэгийн багш /Э.Цэрэнханд/

Хоёр. Сумын өмчид хамаарах хөрөнгүүдийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг жил, улирлаар төлөвлөн ажиллаж хэрэгжилт үр дүнг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнаж үнэлэлт, дүгнэлт авч ажиллахыг комиссын бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 17 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 07 өдөр Дугаар _29_ Хөвийн ам

Салбар зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Ì î í ãî ë Óëñû í Çàñàã çàõèðãààíû í óòàã äýâñãýðèéí í ýãæ ò¿¿í èé óäèðäëàãûí òóõàé хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

Нэг. Сумын нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга : Сумын Засаг дарга /Д.Банзрагч/
Орлогч дарга: Эрүүл мэндийн төвийн дарга /С.Алтанчимэг/
Нарийн бичгийн дарга: Сумын нийгмийн хөгжлийн ажилтан /Ч.Саранзаяа/
Гишүүд: Засаг даргын Тамгын газрын дарга /П.Тогтохжаргал/
Сургуулийн захирал /Р.Гантулга/
Цэцэрлэгийн эрхлэгч /Ч.Бямбасүрэн/
Соёлын төвийн эрхлэгч /Д.Мөнхжаргал/
Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан /Д.Баяраа/
Хурлын байгууллагын төлөөлөл /Г.Ууганбаяр – ИТХ-ын Тэргүүлэгч/
Багийн Засаг даргын төлөөлөл /Д.Болд-Аюуш – 3-р багийн Засаг дарга/
Багийн эмчийн төлөөлөл /Э.Сэргэлэн – 1-р багийн эмч /
Төрийн бус байгууллагын төлөөлөл /Залуучуудын холбооны дарга/
Сайн санааны ажилтны төлөөлөл /Л.Бямбасүрэн – 4-р багийн иргэн/
Бизнес эрхлэгчдийн төлөөлөл /Д. Нансалмаа – Бизнесүүдийн холбооны дарга /
Хувийн хэвшлийн төлөөлөл /Ч. Батцэцэг – ХААН банкны эрхлэгч/

Хоёр. Салбар зөвлөлийн ажиллах дүрэм, журам, ажлын төлөвлөгөөг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулж, хэрэгжилт, явц, үр дүнг хагас бүтэн жилээр дүгнэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг салбар зөвлөлд үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 29 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 10 сарын 07 өдөр　　　　Дугаар _30_　　　　Хөвийн ам

Ажлын төлөвлөгөө батлах тухай

Ìîíãîë Óëñûí Çàñàã çàõèðãàà íóòàã äýâñãýðèéí íýãæ ò¿¿íèé óäèðäëàãûí òóõàé хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎÃÒÎÎÕ íü:

Нэг. “Эрүүл иргэн – Хонгорын ирээдүй” уриан дор зохион байгуулагдах нийгмийн эрүүл мэндийн шилдэг сумын эрүүл мэндийн төв шалгаруулах уралдааны хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

Хоёр. Ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжилт, явц, үр дүнг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж зөвлөмж, чиглэл авч ажиллахыг сумын нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл болон Эрүүл мэндийн төвийн дарга /С.Алтанчимэг/-д үүрэг болгосугай.

Гурав. Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын оролцоог идэвхижүүлж баг, байгууллагын ажил дүгнэх үзүүлэлтэнд нэг үзүүлэлт болгон оруулж дүгнэхийг сумын Засаг дарга /Д. Банзрагч/-д үүрэг болгосугай.

ÄÀÐÃÀ　　　　Á.Ï¯ÐÝÂÑÝÍÃÝ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 10 сарын 14 өдөр Дугаар _32_ Хөвийн ам

⌈Сумын отрын бүс нутаг тогтоох тухай⌉

Монгол Улсын Газрын тухай хуулийн 52- р зүйлийн 52,2 дэх заалт, багуудын ИНХ-аас гаргасан саналыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын 1 дүгээр багийн Давсан даргиат, Элстий, Бага Жаргалант, Зүлэгтий, Мухар нарийн зэрэг газар нутгуудыг 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2014 оны 05 дугаар сарын 01-ны өдөр хүртэл

2 дугаар багийн Ар матгын эх, Өнцгийн эх, Шар усан голын эх зэрэг нутгуудыг 2013 оны 10 дугаар сарын 09-ны өдрөөс 2014 оны 05 дугаар сарын 01-ны өдөр хүртэл

3 дугаар багийн Өлзийт, Нарийн, Хар ус, Тээлийн голын эх, Хөх нуур зэрэг газруудыг 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2014 оны 05 дугаар сарын 01-ны өдөр хүртэл

4 дүгээр багийн Түргэний гол, Налуу, Нарийн Цахир, Хөөврийн ус зэрэг нутгуудыг 2013 оны 10 дугаар сарын 11-ны өдрөөс 2014 оны 05 дугаар сарын 01-ны өдөр хүртэл тус тус отрын бүс нутгаар тогтоосугай.

Хоёр. Дээрхи отрын бүс нутгуудад өөр, аймаг, сумын малчин өрхүүд нутаглуулахгүй байх, арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга / Д. Банзрагч /-д үүрэг болгосугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 10 сарын 14 өдөр Дугаар _32_ Хөвийн ам

Ажил сайжруулах тухай

Сумын соёлын төвийн 2013 оны 9 сарын ажлын тайланг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Тус соёлын төв нь 2013 онд 5 орон тоотой ажиллан улсын төсвөөс эхний 9 сард 27667.9 мян төгрөг төсөвлөснөөс 27329.0 мян төгрөг зарцуулан, өөрийн орлого 1000.0 төгрөг оруулахаас 587.0 мян төгрөг оруулсан ба ажилчдын ажлын хариуцлага, цаг ашиглалт муу, соёлын төвийн эрхлэгчийн ажлын хариуцлага сул байгаа зэрэг дутагдлуудыг хэлэлцээд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын соёлын төвийн эрхлэгч Д.Мөнхжаргалд үүрэг болгох нь:

1.Өөрийн орлогын дутуу 413.0 мян төгрөгийг оруулан соёлын төвийн эд хогшил худалдан авах.

2.0йрын хугацаанд хөгжмийн багштай болох асуудлыг судлан яаралтай арга хэмжээг авч, хөгжмийн багшийн асуудлыг шийдвэрлэх.

3. Номын сангийн явуулын үйлчилгээгээр баг, айл өрх бүрт хүргэн ажиллах, явуулсан ажил үйлчилгээний тайланг дэлгэрэнгүй гаргах.

4. Номын санчид олгож буй давхар ажилласны 40 хувийг 10 дугаар сарын 01- ний өдрөөс зогсоох.

5. Дугуйлангуудын үйл ажиллагааг идэвхижүүлж, насанд хүрэгчдийг хамруулах.

6. Морин хуур, уртын дууны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах.

7. Угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлж сургалтыг зохион байгуулах, угийн бичиг хөтөлдөг иргэдийн тоог нэмэгдүүлэх.

8. Соёлын төвийн үйл ажиллагааны төрөөс баримтлаж буй бодлогод нийцүүлэн сумын бодлого боловсруулан хэрэгжүүлэх.

9. Ажилтан албан хаагчдынхаа ажлын цаг ашиглалтыг сайжруулж, цагийн бүртгэлд хяналт тавьж ажиллах.

Хоёр. Өгөгдсөн үүрэг даалгаварын дагуу төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилт тайланг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэхийг сумын соёлын төвийн эрхлэгч Д.Мөнхжаргалд даалгасугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 14 өдөр Дугаар _32_ Хөвийн ам

Ажил эрчимжүүлэх тухай

Сумын 5 дугаар багийн Засаг дарга Д. Дагважамцын 2013 онд хийж гүйцэтгэж байгаа ажлын тайланг хэлэлцээд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. 5 дугаар багийн Засаг дарга Д. Дагважамцад үүрэг болгох нь:

1. Хог тээврийн авто машиныг хуваарийн дагуу ажиллуулах нуруугаар хог тээвэрлэж асгадаг явдлыг зогсоох.

2. Нохой тэжээхэд мөрдөх журмыг сумын төвд чанд мөрдөн ажиллуулах.

3. Усны машины зогсоолыг бий болгож ард иргэдэд үйлчлэх.

4. Стандартын бохир, муу усны цооногийн нарийн судалгааг гаргаж дутуу айл өрхүүдэд шаардлага тавин Ариун цэврийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллуулах.

5. Нийтийн цэвэрлэгээг ойрын үед хийх.

Хоёр. Дээр өгөгдсөн үүрэг даалгаварын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангаа 2013 оны 11 сарын 25-ны өдрийн Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг 5 дугаар багийн Засаг дарга /Д. Дагважамц-д/ даалгасугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 11 сарын 21 өдөр Дугаар _37_ Хөвийн ам

Согтууруулах ундаа худалдаалах
цэгийн тоог тогтоох тухай

Сумд согтууруулах ундаа худалдаалах, үйлчлэх цэгийн тоо хэмжээг тогтоох журамлах тухай сумын мал эмнэлэг үржлийн тасгийн малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Д.Юмчинхорлоогийн илтгэлийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Тус сумд худалдааны үйл ажиллагаа явуулж байгаа 16 цэг байгаа ба үүнээс 10 нь 2012 онд архи худалдаалах тухай зөвшөөрөлтэй байсан байна. 2013 оны 11 сарын байдлаар архи худалдаалах тусгай зөвшөөрөлтэй С. Наранчимэг эзэнтэй “Наран”, Б.Нансалмаа эззнтэй “Гурванбулаг”, Г.Ууганбаяр эзэнтэй “Ноён хайрхан”, Ц.Бужидмаа эзэнтэй “Төгс заяа” дэлгүүрүүд үйл ажиллагаа явуулж байгаа ба архи худалдаалах, түүгээр үйлчлэх цэгийн тоог аль болох цөөн байлгах шаардлагатайг тэмдэглээд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын хэмжээнд архи худалдаалах тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоог 4-өөс дээшгүй байхаар тогтоосугай.

Хоёр. Архи худалдаалах үйлчлэх цэг тэдгээрийг сонгон шалгаруулах журмыг Иргэний танхимаар хэлэлцүүлэн гарсан саналыг ИТХ-ын хуралдаанд өргөн мэдүүлэн шийдвэрлүүлж ажиллахыг мал эмнэлэг үржпийн тасгийн малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Д. Юмчинхорлоод даалгасугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2013 оны 12 сарын 04 өдөр Дугаар _39_ Хөвийн ам

⌐ Хуралдаан зарлан хуралдуулах тухай ¬

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын ИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдааныг 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 9 цагт сумын ЗДТГ-ын хурлын танхимд хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1. Сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2013 оны гүйцэтгэл, 2014 оны үндсэн чиглэлийн тухай Сумын Засаг дарга

2. Сумын Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн эхний жилийн хэрэгжилтийн тухай.
Сумын Засаг дарга

3. Сумын газар зохион байгуулалтын 2013 оны төлөвлөгөөний биелэлт, 2014 оны төлөвлөгөөний тухай.
Газрын даамал

4. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтын тухай.
Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн ахпагч

5. Сумын Төсвийн 2013 оны гүйцэтгэл, 2014 оны төсвийн тухай.
Төрийн сангийн төлөөлөгч

6. Бусад асуудал

Хоёр. Хуралдааны бэлтгэл хангах ажлын хөтөлбөр боловсруулж мөрдөн ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчид, нарийн бичгийн даргын ажлыг түр орлон гүйцэтгэгч Р. Цогт, Тамгын газрын дарга Б. Цэдэндамба нарт үүрэг болгосугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 02 өдөр Дугаар _15_ Хөвийн ам

Хуралдааны тов тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын ИТХ-ын ээлжит бус 8 дугаар хуралдааныг 2014 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 10 цагт сумын Соёлын төвд нээлттэй хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

1. Уул уурхайн өнөөгийн байдал тулгамдаж буй асуудлууд
2. Орон нутгийн хөгжлийн сангийн 2014 оны зарцуулалтын тухай
3. Сумын түүхт 90 жилийн ойн хандивын тухай
4. Бусад асуудал

Хоёр. Хуралдааны бэлтгэл хангах ажлын хөтөлбөрийг хавсаралтаар баталсугай.

Гурав. Хуралдааны бэлтгэл хангах ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг ИТХ-ын нарийн бичгийн дарга С.Алтанцэцэг, ЗДТГ-ын дарга Б.Цэдэндамбаа нарт үүрэг болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 10 сарын 28 өдөр Дугаар _16_ Хөвийн ам

┌ Õóðàëäààí çàðëàí õóðàëäóóëàõ òóõàé ┐

Ìîíãîë Óëñûí Çàñàã çàõèðãààíû íóòàã äýâñãýð íýãæ ò¿¿íèé óäèðäëàãûí òóõàé õóóëèéí 20 äóãààð ç¿éëèéí 20.1.1 äýõ çààëò, 25 äóãààð ç¿éëèéí 1 äýõ çààëòûã ¿íäýñëýí Ñóìûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎÃÒÎÎÕ íü:

1. Ñóìûí ÈÒÕ-ûí ýýëæèò 9 äүгээð õóðàëäààíûã 2014 îíû 11 äүгээð ñàðûí 12-íы ºäðèéí 10 öàãò сумын Соёлын төвд õóðàëäóóëæ äàðààõ àñóóäëóóäûã õýëýëö¿¿ëñ¿ãýé. ¯¿íä:

- Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн эхний 2 жилийн хэрэгжилтийн тухай. Илтгэгч: Сумын Засаг дарга

- Сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт эхний 3 улирлын байдлаар. Илтгэгч: Сумын Засаг дарга

- Ñóìûí ÈÒÕ-ûí тогтоолын хэрэгжилт. ИТХ-ын нарийн бичгийн дарга

- Ñóìûí ÈÒÕ-ûí даргын õèéñýí àæëûí òàéëàí. ИТХ-ын дарга

- Çîõèîí áàéãóóëàëòûí àñóóäàë

- Бусад асуудал

2. Õóðàëäààíд хэлэлцэх асуудлуудыг урьдчилан 2014 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хэлэлцэх тул хэлэлцэх асуудлыг стандартын дагуу бэлтгэн 11-р сарын 07-ны дотор Тэргүүлэгчдэд урьдчилан хүргүүлэх, хуралдааны бэлтгэл зохион байгуулалтыг хангаж ажиллахыг сумын ЗДТГ-ын даргад даалгасугай.

3. Хуралдааны бэлтгэл, техник зохион байгуулалтыг хanган ажиллахыг сумын иргэний танхимын ажилтанд үүрэг болгосугай.

ХУРАЛДААН ÄÀÐÃÀЛАГЧ Á. БАЯНДАЛАЙ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 05 өдөр Дугаар _16_ Хөвийн ам

Õóðàëäààí çàðëàí õóðàëäóóëàõ òóõàé

Ìîíãîë Óëñûí Çàñàã çàõèðãààíû íóòàã äýâñãýðèéí íýãæ òºðèéí óäèðäëàãûí òóõàé õóóëèéí 20 äóãààð ç¿éëèéí 20.1.1 äýõ çààëò, 25 äóãààð ç¿éëèéí 1 äýõ çààëòûã ¿íäýñëýí ñóìûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎÃÒÎÎÕ íü:

1. Ñóìûí ÈÒÕ-ûí ýýëæèò 9 äүгээð õóðàëäààíûã 2014 îíû 12 äугааð ñàðûí 19-íий ºäðèéí 09 öàãò сумын Соёлын төвд õóðàëäóóëæ äàðààõ àñóóäëóóäûã õýëýëö¿¿ëñ¿ãýé. ¯¿íä:

- Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн эхний 2 жилийн хэрэгжилтийн тухай. Илтгэгч: Сумын Засаг дарга

- Сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2015 оны үндсэн чиглэл батлах тухай. Илтгэгч: Сумын Засаг дарга

- Сумын 2014 оны төсвийн гүйцэтгэл, 2015 оны төсөв батлах тухай.

- Ñóìûí ÈÒÕ-ûí тогтоолын хэрэгжилт.

- Ñóìûí ÈÒÕ-ûí õèéñýí àæëûí òàéëàí.

- Çîõèîí áàéãóóëàëòûí àñóóäàë

- Бусад асуудал

2. Õóðàëäààíû áýëòãýë õàíãàx ажлын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

3. Хуралдааны бэлтгэл хангах ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ÇÄÒÃ-ûí äàðãà нарт äààëãàñóãàé.

ÄÀÐÃÀ Á. ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 26 өдөр Дугаар _17_ Хөвийн ам

Урамшуулал олгох òóõàé

Ì î í ãî ë Óëñû í Çàñàã çàõèðãààíû íóòàã äýâñãýðèéí íýãæ ò¿¿íèé óäèðäëàãûí òóõàé õóóëèéí 25 äóãààð ç¿éëèéí 25.1 äýõ çààëò, 16 äóãààð ç¿éëèéí 16.1 äýõ çààëòûã ¿í äýñëýí ñóì ûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õí ü:

1. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд тус бүр хавсралтад заагдсан хэмжээгээр нийт 750000 /долоон зуун тавин/ мянган төгрөгийн урамшуулал олгосугай.

2. Дээрх урамшуулалд шаардагдах 750000 /долоон зуун тавин/ мянган төгрөгийн цалингийн сангаас зарцуулахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга С.Алтанцэцэг, нягтлан бодогч Э.Жавхлан нарт зөвшөөрсүгэй.

ÄÀÐÃÀ Á. ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 09 өдөр Дугаар _01_ Пионер толгой

Ñàéí ìàë÷èí øàëãàðóóëàõ ñàíàëûã
äýìæèõ òóõàé

"Аймгийн сайн малчин" шалгаруулах тухай 1, 3 дугаар áàãèéí Èðãýäèéí Íèéòèéí Õóðëûí òýìäýãëýë, ñóìûí Çàñàã äàðãûí çºâëºëèéí ñàíàë, ìàë÷íû òîäîðõîéëîëò, àæëûí ¿ç¿¿ëýëò¿¿äèéã õýëýëöýýä Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2009 оны 436 дугаар захирамжыг тус тус үндэслэн ñóìûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎÃÒÎÎÕ íü:

1. "Аймгийн сайн малчин" шалгаруулах тухай журам шалгуурыг ханган багийн ÈÍÕ-ын санал, сумын Засаг даргын зөвлөлийн хурлын олонхийн саналаар "Аймгийн ñàéí малчин"-íä øàëãàðóóëàõààð äýìæèãäñýí 1 дүгээр багийн малчин Чойжин îâîãòîé Энх-Амгаланг "Аймгийн сайн малчин"-íä øàëãàðóóëàõ ñàíàëûã äýìæèí óëàìæèëñóãàé.

2. "Аймгийн сайн малчин" шалгаруулах тухай журам шалгуурыг ханган багийн ÈÍÕ-ын санал, сумын Засаг даргын зөвлөлийн хурлын олонхийн саналаар "Аймгийн сайн малчин"-íä øàëãàðóóëàõààð äýìæèãäñýí 2 дугаар багийн малчин Доржбал îâîãòîé Ганболд "Аймгийн сайн малчин"-íä øàëãàðóóëàõ ñàíàëûã äýìæèí óëàìæèëñóãàé.

3. Ч.Энх-Амгалан, Д.Ганболд нарын àæëûí òîäîðõîéëîëò, ¿ç¿¿ëýëò, àíêåò õîëáîãäîõ áàðèìò áè÷ãèéã çààâàðûí äàãóó á¿ðä¿¿ëæ àéìãèéí Õºãæëèéí áîäëîãûí õýëòýñò óëàìæëàõûã ñóìûí Çàñàã äàðãûí Òàìãûí ãàçðûí äàðãà Б.Цэдэндамбаад даалгañóãàé.

ÄÀÐÃÀ Á.Ï¯ÐÝÂÑÝÍÃÝ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2015 оны 01 сарын 09 өдөр　　　　Дугаар _02_　　　　Пионер толгой

Øèí ý õîò àéëààð øàëãàðóóëàõ ñàíàëûã
äýìæèõ òóõàé

“Шинэ хот айл” шалгаруулах тухай 3 дугаар áàãèéí Èðãýäèéí Íèéòèéí Õóðëûí òýìäýãëýë, ñóìûí Çàñàã äàðãûí çºâëºëèéí ñàíàë, ìàë÷íû òîäîðõîéëîëò, àæëûí ¿ç¿¿ëýëò¿¿äèéã õýëýëöýýä Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн ñóìûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎÃÒÎÎÕ íü:

1. “Шинэ хот айл” шалгаруулах тухай журам шалгуурыг ханган багийн ИНХ-ûí ñàíàë, ñóìûí Çàñàã äàðãûí çºâëºëèéí õóðëûí îëîíõèéí ñàíàëààð “Шинэ хот айл”-аар øàëãàðóóëàõààð äýìæèãäñýí 3 дугаар багийн малчин Дэндэв îâîãòîé Сандагжавыг “Шинэ хот айл”-аар øàëãàðóóëàõ ñàíàëûã äýìæèí óëàìæèëñóãàé.

2. Д.Сандагжавын àæëûí òîäîðõîéëîëò, ¿ç¿¿ëýëò, àíêåò õîëáîãäîõ áàðèìò áè÷ãèéã çààâðûí äàãóó á¿ðä¿¿ëæ àéìãèéí Õºãæëèéí áîäëîãûí õýëòýñò óëàìæëàõûã ñóìûí Çàñàã äàðãûí Òàìãûí ãàçðûí äàðãà Б.Цэдэндамбааä даалгañóãàé.

ÄÀÐÃÀ　　　　Á.Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2015 оны 01 сарын 09 өдөр Дугаар _04_ Пионер толгой

Çº âëº ëийн бүрэлдэхүүнд нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Ì î í ãî ë Óëñû í Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ òóõàé õóóëèéí 16 äóãààð ç¿éëèéí 1 äýõ çààëò, Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013.02.20-ны өдрийн 08 дугаар тогтоолыг тус тус ¿í äýñëýí ñóì û í ÈÒÕ-û í Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

1. Ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ àæëû ã ñóì û í õýì æýýí ä çî õèöóóëàõ î ðî í òî î í û áóñ çº âëº ëèéí бүрэлдэхүүнд äàðààõ àëáàí òóø ààëòí óóäû г нэмж батлсугай. ¯¿í ä:

Сумын ЗДТГ-ын нийгмийн хөгжлийн ажилтан

Сумын халамжийн мэргэжилтэн

2. Çî õèöóóëàõ çº âëº ëä äààëãàõ í ü:

Àæëû í ÿâö òàéëàí ãàà хагас, бүтэн жилээр дүгнэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулан, àéì ãèéí Ãýì ò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ àæëû ã çî õèõöóóëàõ çº âëº ëä ÿâóóëæ ÷èãëýë çº âëº ì æ àâ÷ àæèëëàхыг зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай õî ëáî ãäóóëàí 2013 î í û 02 äугааð ñàðû í 20-í ы º äðèéí 08 äугааð òî ãòî î ëû н хоёрын 2 дахь заалтыг õ¿÷èí ã¿é áî ëãî ñóãàé.

ÄÀÐÃÀ Á.Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 20 өдөр Дугаар _05_ Пионер толгой

⌈ Õóðàëäààí çàðëàí õóðàëäóóëàõ òóõàé ⌉

Ì î í ãî ë Óëñûí Çàñàã çàõèðãàà í óòàã äýâñãýðèéí í ýãæ ò¿¿í èé óäèðäëàãûí òóõàé õóóëèéí 25 äóãààð ç¿éëèéí 1 äýõ çààëò, 20 äóãààð ç¿éëèéí 20.1.1 äýõ çààëòыг ¿í äýñëýí ñóì ûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

1. Ñóì ûí ÈÒÕ-ûí ýýëæèò бус 10 äугааð õóðàëäààí û ã 2015 î í û 02 äугааð ñàðûí 04-í ий º äðèéí 10 öàãò сумын Иргэний танхимд õóðàëäóóëæ äàðààõ àñóóäëóóäûã õýëýëö¿¿ëñ¿ãýé. ¯¿í ä:

- 2014 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2015 оны төлөвлөгөө батлах тухай

- Зохион байгуулалтын асуудал

- Сумд хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тухай /байгууллага тус бүрээр/

- Үнэлгээний хороодын ажлын тайлан

- Бусад асуудал

2. Õóðàëäààí û áýëòãýë õàí ãàх ажлын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

3. Хуралдааны бэлтгэл хангах ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ÇÄÒÃ-ûí äàðãà нарт äààëãàñóãàé.

ÄÀÐÃÀ Á. ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 20 өдөр Дугаар _04_ Пионер толгой

Алдарт эх одонгоор шагнагдах
эхчүүдийн материал хүргүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 71 дүгээр зарлигаар батлагдсан журмыг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Тус сумаас “Алдарт эх”-ийн одонгоор шагнагдах эхчүүдийн нэрийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дээрх эхчүүдийн материалуудыг бүрдүүлэн аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хугацаанд нь хүргүүлэхийг сумын ЗДТГ-ын дарга Б.Цэдэндамбаад даалгасугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2015 оны 01 сарын 20 өдөр Дугаар _07_ Пионер толгой

Бэлчээрийн шилдэг менежменттэй сум
шалгаруулах санал äýì æèõ òóõàé

“Бэлчээрийн шилдэг менежменттэй сум” шалгаруулах тухай журмын хэрэгжилтийг õýëýëöýýä Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2013 оны 293 дугаар захирамжыг тус тус үндэслэн ñóì ûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

1. “Бэлчээрийн шилдэг менежменттэй сум” øàëãàðóóëàõ òóõàé æóðмын øàëãóóðûã хангансан тул “Бэлчээрийн шилдэг менежменттэй сум” шалгаруулах сонгон шалгаруулалтанд оролцох саналыг дэмжсүгэй.

2. Сумын òî äî ðõî éëî ëò, ¿ç¿¿ëýëò õî ëáî ãäî õ áàðèì ò áè÷ãèéã çààâðûí äàãóó á¿ðä¿¿ëæ àéì ãèéí Õº ãæëèéí áî äëî ãûí õýëòýñò óëàì æëàõûã ñóì ûí Çàñàã äàðãûí Òàì ãûí ãàçðûí äàðãà Б.Цэдэндамбаа, МЭҮТ-ийн дарга М.Ариунсан нарт даалгañóãàé.

ÄÀÐÃÀ Á.Ï¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2015 оны 01 сарын 23 өдөр Дугаар _08_ Пионер толгой

Зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Сумын нийгмийн халамжийн ажилтан Б.Циегийн саналыг хэлэлцээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, 27.2 дахь заалт, 27.3 дахь заалт, 27.6 дахь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын амьжиргааг дэмжих зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Дарга: Ч.Эрдэнэ-Очир - Сумын Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Б.Циеэ - Сумын нийгмийн халамжийн ажилтан

Гишүүд: П.Тогтохжаргал - Төрийн сангийн төлөөлөгч

Д.Мөнхзул - Сургуулийн эмч

Т.Наранцацрал – Эрүүл мэндийн төвийн сувилагч

Ч.Сандив – иргэний төлөөлөл

Р.Чулуунбаатар – иргэний төлөөлөл

Хоёр. Нийгмийн халамжийн тухай хууль, түүнтэй холбогдолтой гаргасан хууль тогтоомж бусад эрх зүйн актуудыг мөрдлөг болгон ажиллаж ажлын явц, үр дүнг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд улирал бүр тайлагнаж ажиллахыг зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 13 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2015 оны 01 сарын 23 өдөр Дугаар _09_ Пионер толгой

Комисс шинэчлэн байгуулах тухай

Ì î í ãî ë Óëñû í Çàñàã çàõèðãàà í óòàã äýâñãýðèéí í ýãæ ò¿¿í èé óäèðäëàãû í òóõàé хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “л” дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалтыг тус тус үндэслэ́í ñóì û í ÈÒÕ-û í Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

Нэг. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах эрх бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай. Үүнд:

Комиссын дарга: Сумын Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Санхүүгийн албаны дарга

Гишүүд: МЭҮТ-ийн бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтан

Бага ангийн сургалтын менежер

Эрүүл мэндийн төвийн ахлах сувилагч

Цэцэрлэгийн багш /С.Саранчимэг/

Соёлын төв бүжгийн багш

Хоёр. Сумын өмчид хамаарах хөрөнгүүдийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг жил, улирлаар төлөвлөн ажиллаж хэрэгжилт үр дүнг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнаж үнэлэлт, дүгнэлт авч ажиллахыг комиссын бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

Гурав. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 28 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃÝ

# БАЯНХОНГОР АЙМГИЙН
# ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
# ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2015 оны 01 сарын 23 өдөр | Дугаар _10_ | Пионер толгой

Тусгай хамгаалалтанд авах газар нутгийн
санал уламжлах тухай

Тус сумын Хөх нуур, Шар ус, Хар ус голуудын эх орчмын нутгийг байгалийн цогцолборт газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авснаар цэнгэг усны багагүй нөөц бүхий Хангайн гол нурууны өндөр сүрлэг уул нуруud, мөсдлийн гаралтай нуурууд, түргэн урсгалт услаг ихтэй голууд бүхий үзэсгэлэнт энэ нутгийг хойч үедээ өвлүүлж үлдээх нөгөө талаар тоо толгой, байршил нутаг нь багасаж буй өндөр уулын амьтад болох янгир, аргаль, буга зэрэг амьтдын байран амьдрах орчныг цогцолбороор хамгаалах, өсөн үржих таатай нөхцөл бүрдэхийг тэмдэглээд Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Байгалийн цогцолборт газарт оруулах газар нутгийн цэг солбицлыг 1 дүгээр хавсралтаар, зургийг 2-р хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Улсын тусгай хамгаалалттай газрын Байгалийн цогцолбор газрын ангилалд хойд цэг Хар усан даваа, зүүн цэг Шар усан даваа, Өнцгийн гол, урд цэг Муруйн даваа, Баруун цэг Түргэний ам хүртэлх 121231.34 га талбайг Хөх нуур-Бумбатын байгалийн цогцолборт газрын ангилалд оруулах саналыг дэмжиж холбогдох дээд байгууллагад уламжилсугай.

ДАРГА Б.ПҮРЭВСЭНГЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2015 оны 07 сарын 24 өдөр Дугаар _11_ Пионер толгой

“Жи Энд Юу Гоулд” ХХК-ны
ашигт малтмал олборлох үйл ажиллагааг
зогсоох тухай

Өвөр хөшөөтийн 12806А лицензтэй тусгай зөвшөөрөлтэй талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж буй “Жи Энд Юу Гоулд” ХХК-ны уурхайн үйл ажиллагааг хүлээн авах комисс ажиллаагүй байхад ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа эхлүүлж ажилласан, Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Э.Энхбатын 2015.07.06-ны өдрийн 1/190 тоот албан бичгийг зөрчин нөхөн сэргээлтээ хийгээгүй байж хөрс хуулалт хийж олборлолт явуулж байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Ì î í ãî ë Óëñûí Çàñàã çàõèðãààíû í óòàã äýâñãýðèéí í ýãæ ò¿¿í èé óäèðäëàãûí òóõàé õóóëèéí 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх заалт, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, 39 дүгээр зүйлийн 39.7 дахь заалтыг тус тус ¿í äýñëýí ñóì ûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎ ÃÒÎ Î Õ í ü:

1. Тус сумын нутаг Өвөр хөшөөтийн 12806А лицензтэй тусгай зөвшөөрөлтэй талбайд ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулж буй “Жи Энд Юу Гоулд” ХХК-ны уурхайн үйл ажиллагааг зогсоосугай.

2. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга Д.Банзрагч, Байгаль орчны хяналын улсын байцаагч Ш.Нархүү нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж явц үр дүнг ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга Д.Банзрагчид үүрэг болгосугай.

ÄÀÐÃÀ Á. Ï ¯ÐÝÂÑÝÍ ÃЭ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2015 оны 07 сарын 24 өдөр Дугаар _12_ Пионер толгой

Õóðàëäààí çàðëàí õóðàëäóóëàõ òóõàé

Ìîíãîë Óëñûí Çàñàã çàõèðãàà íóòàã äýâñãýðèéí íýãæ ò¿¿íèé óäèðäëàãûí òóõàé õóóëèéí 25 äóãààð ç¿éëèéí 1 äýõ çààëò, 20 äóãààð ç¿éëèéí 20.1.1 äýõ çààëòыг ¿íäýñëýí ñóìûí ÈÒÕ-ûí Òýðã¿¿ëýã÷äýýñ ÒÎÃÒÎÎÕ íü:

1. Ñóìûí ÈÒÕ-ûí ýýëæèò 10 äугааð õóðàëäààíûã 2015 îíû 08 äугааð ñàðûí 10-íы ºäðèéí 09 öàãò сумын ЗДТГ-ын хурлын зааланд õóðàëäóóëæ äàðààõ àñóóäëóóäûã õýëýëö¿¿ëñ¿ãýé. ¯¿íä:

- Сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2015 оны үндсэн чиглэлийн эхний хагас жилийн хэрэгжилтийн тайлан
- Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт
- 2015 оны төсвийн тодотгол
- 2014 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2015 оны төлөвлөгөө батлах тухай
- Уул уурхайн асуудал
- ИТХ-ын эхний хагас жилийн ажлын тайлан
- Сумын ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийн тайлан /хагас жилийн/
- Бусад асуудал

2. Õóðàëäààíû áýëòãýë õàíãàx ажлын хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

3. Хуралдааны бэлтгэл хангах ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, ÇÀÒÃ-ûí äàðãà нарт äààëãàñóãàé.

ÄÀÐÃÀ Á. ПҮРЭВСЭНГЭ